

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1.	Оршил	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ШАРАВЖАМЦ
ТАНАА

2019.03.04 № 06/381
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Биеийн тамир, спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биеийн тамир, спортын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Биеийн тамир, спортын газрын дарга Ц.Шаравжамц Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Шонхор үнэлгээ, аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв.

Биеийн тамир, спортын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Шонхор үнэлгээ Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/44 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Биеийн тамир, спортын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Биеийн тамир, спортын газар нь "Хөгжлийн чиг хандлага, хүн амын спорт, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх хэрэгцээнд нийцүүлэн судалгаанд суурилсан ажил үйлчилгээг төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, эрүүл чийрэг, өрсөлдөх ур чадвартай хүний нөөц, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны чиглэл, эрх, үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, биеийн тамир, спортын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Бие бялдрын түвшин тогтоох стандартыг боловсруулан, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх;
- Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах спортын холбоог сонгон шалгаруулах;
- Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх;
- Хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажлыг зохион байгуулах;

- Улсын хэмжээнд зохион байгуулах спортын наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, тэмцээний зохион байгуулалтыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;
- Бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- Допингийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Биеийн тамир, спортын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Биеийн тамир, спортын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Биеийн тамир, спортын тухай хууль

Тайлант хугацаанд Биеийн тамир, спортын сайдын 2018 оны А/167 тоот тушаалаар "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийн сонгох, санхүүжүүлэх" журмыг баталсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд БСШУС-ын сайдын 2017 оны А/40 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрдөн ажилладаг байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцжээ.

Биеийн тамир, спортын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Биеийн тамир, спортын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Интер актив Ай Би ХХК-ийн "Эмералд" программ хангамж" ашигладаг байна.

Биеийн тамир, спортын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Биеийн тамир, спортын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар сонгов.

Нийт орлогоор материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгосон нь улсын төсвийн урсгал санхүүжилтээс гадна үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлттэй холбоотой юм.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны нийт орлого 11,325,243.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 113,252.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар 372,073.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 7,905.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 68,756.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын явцад хийсэн залруулгын талаархи мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	68,756.0	
2	Албан шаардлага өгсөн	1	7,905.0	
	Дүн	3	76,661.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Худалдан авах ажиллагаанд хийсэн сорилын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын "Спорт ба хөгжил" улсын зөвлөлөгөөны лого, шторк хийх видео танилцуулга, баннер, олимпын тэмдэгт зоосны загварыг хийлгэх гэрээний хүлээлгэн өгөх эцсийн хугацаа 2018 оны 10 сарын 18-нд байсан боловч 7,905.0 мянган төгрөгийн гэрээт ажил хугацаандаа хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Ханлиг Тайшир" ХХК-иас гэрээний үүргийн биелэлт шаардах, байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлж байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Түрээсийн авлагын тооцоотой байгаа "Адидас Дабль Ди" ХХК, Голд Жим клуб, "Жим Ретейл" ХХК-иудаас он удаан жил үргэлжилсэн авлагатай байгаа ба авлага барагдуулсан эсэхэд анхаарах

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Биеийн тамир, спортын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 9,977,685.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 9,953,619.0 мянган төгрөг буюу 99.75 хувьтай байгаа нь 2018 оны жилийн эцсээр 24,066.3 мянган төгрөгийн төсвийн дутуу зарцуулалттай гарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 90,000.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 103,325.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 13,325.0 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь дамжсан өр төлбөрийг барагдуулсан болон А заалны ашиглалтыг сайжруулсантай холбоотой.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Биеийн тамир, спортын газрын шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Тус байгууллага 16 мэдээллийг шилэн дансанд оруулахаас 11 мэдээллийг оруулж 5 мэдээллийг огт оруулаагүй, дараа жилийн төсвийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайланг жилийн эцсийн байдлаар шилэн данс руу оруулахдаа хугацаа хоцорч байршуулсан.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 91 хувьтай байна.

Энэ нь түрээсийн тооцооны авлагыг шүүх хяналтын байгууллагад шилүүлсэн бөгөөд одоогоор бүрэн барагдуулаагүй байгаатай холбоотой.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Биеийн тамир, спортын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

3.1.1 Илрүүлэлт:

Төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, эрхэлсэн ажилдаа гаргасан амжилтыг үл харгалзан сар бүр ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай журам”-ын 2 дахь хэсэгт заасан “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.” гэсэнтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Цалин, түүнтэй холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, албан хаагчдын урамшууллын бодлого үр дүнгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдлийг холбогдох журамд нийцүүлэн олгох, цалин түүний тооцоололд дотоод хяналтыг сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 оны санхүүгийн тайланд 41 байгууллагын 687,677.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагийн 68,756.0 мянган төгрөгийн авлага нь 1 жилээс дээш хугацаатай авлага байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Он удаан жил үргэлжилсэн гэрээ болон харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний хугацаа болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч, цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,232,984,526.58</u>	<u>1,473,669,830.93</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	1,000,329.10
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.0	1,000,329.10
31110	Төгрөг	0.0	1,000,000.00
31140	Касс арилжааны банк	0.0	329.10
33	АВЛАГА	468,986,659.68	687,677,571.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,636,234.00	0.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	21,712,007.48	18,969,400.48
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.0	2,285,200.00
335	Бусад авлага	435,638,418.20	666,422,971.00
3351	Байгууллагаас авах авлага	435,638,418.20	661,340,359.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.0	5,082,612.00
35	БАРАА МАТЕРИАЛ	763,997,866.90	784,991,930.35
351	Түүхий эд материал	732,855,858.40	737,790,191.85
35110	Тусгай зориулалттай материал	598,180,520.00	552,846,539.65
35130	Эм боох материал	134,675,338.40	184,943,652.20
354	Хангамжийн материал	31,142,008.50	47,201,738.50
35410	Бичиг хэргийн материал	13,291,200.00	29,323,550.00
35420	Аж ахуйн материал	17,550,888.50	17,878,188.50
35440	Түлш, шатах тослох материал	299,920.00	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,242,035,285.14</u>	<u>1,862,677,543.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,242,035,285.14	1,862,677,543.21
392	Биет хөрөнгө	1,233,468,613.18	1,517,627,090.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,919,041,584.00	879,033,567.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	5,538,579,177.45	50,136,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,163,016.57	121,163,016.57
39204	Хуримтлагдсан элэгдэл	35,605,831.85	46,853,339.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	412,981,458.75	817,458,921.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	379,842,518.63	545,974,260.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,699,956.49	159,769,041.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	127,793,132.01	135,971,899.79
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	372,073,873.06	0.0
39212	Хуримтлагдсан элэгдэл	82,099,842.88	0.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,029,538,424.80	1,031,538,424.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	585,109,197.67	712,400,381.94
393	Биет бус хөрөнгө	8,566,671.96	345,050,453.20
39301	Програм хангамж	26,702,800.00	26,702,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	18,136,128.04	22,419,466.80
39303	Бусад биет бус хөрөнгө	0.0	340,767,120.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,475,019,811.72</u>	<u>3,336,347,374.14</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,927,000.00</u>	<u>18,497,701.00</u>

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,927,000.00	18,497,701.00
413	Өглөг	9,900,000.00	18,497,701.00
4136	Бусад өглөг	9,900,000.00	18,497,701.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,900,000.00	18,497,701.00
414	Урьдчилж орсон орлого	27,000.00	0.0
41440	Бусад урьдчилж орсон орлого	27,000.00	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,465,092,811.72</u>	<u>3,317,849,673.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,465,092,811.72	3,317,849,673.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	944,046,039.52	1,284,813,159.52
51101	Өмч: - төрийн	944,046,039.52	1,284,813,159.52
512	Хуримтлагдсан үр дүн	471,013,027.46	459,026,379.05
51210	Өмнөх үеийн үр дүн	-82,611,083.46	471,013,027.46
51220	Тайлант үеийн үр дүн	553,624,110.92	-11,986,648.41
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.0	0.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,050,033,744.74	1,574,010,134.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,475,019,811.72</u>	<u>3,336,347,374.14</u>

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,270,650,019.59	11,325,242,707.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	501,357,019.59	150,185,608.00
120	Нийтлэг татварын бус орлого	501,357,019.59	150,185,608.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	501,357,019.59	150,185,608.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,488,514.48	150,185,608.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	309,868,505.11	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,769,293,000.00	11,175,057,099.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,769,293,000.00	9,887,685,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,769,293,000.00	9,887,685,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	1,287,371,799.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	1,204,497,995.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	82,873,804.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,717,025,908.67	11,337,229,355.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,717,025,908.67	11,337,229,355.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,604,952,389.50	11,267,957,055.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,322,616,839.00	1,356,833,187.30
210101	Үндсэн цалин	461,218,156.00	471,099,039.00
210104	Урамшуулал	0.0	60,915,948.30
210105	Гэрээт ажлын хөлс	861,398,683.00	824,818,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,259,833.10	161,899,269.10
210201	Тэтгэврийн даатгал	93,444,178.73	161,899,269.10
210205	Эрүүл мэндийн даатгал	51,815,654.37	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,292,582.79	185,788,615.49
210301	Гэрэл, цахилгаан	74,653,427.00	84,140,810.00
210302	Түлш, халаалт	75,970,694.00	78,608,300.00
210303	Цэвэр, бохир ус	22,668,461.79	23,039,505.49
2104	Хангамж, бараа материалын зардал	73,871,429.00	406,261,530.17
210401	Бичиг хэрэг	3,624,400.00	3,821,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,729,010.00	2,304,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,629,015.00	4,497,141.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,248,000.00	3,960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,641,004.00	391,679,248.80
2105	Нормативт зардал	96,300,000.00	2,538,499.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	96,300,000.00	2,538,499.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,837,988.00	51,686,662.00
210604	Урсгал засвар	40,837,988.00	51,686,662.00
2107	Томилот, зочны зардал	1,119,400.00	902,950.00
210702	Дотоод албан томилот	1,119,400.00	902,950.00

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,068,789,545.54	5,883,967,366.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,066,537,133.54	5,837,036,342.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	870,900.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,200.00	910,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,200.00	0.0
210807	Газрын төлбөр	926,112.00	926,112.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	0.0	40,894,812.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	682,864,772.07	3,218,078,975.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	275,595,557.00	2,889,427,850.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,612,820.00	18,077,199.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	405,656,395.07	310,573,926.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,073,519.17	69,272,300.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	32,644,005.00	0.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	32,644,005.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,436,300.00	19,968,208.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,800,000.00	0.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	18,968,208.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,636,300.00	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,993,214.17	49,304,092.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,993,214.17	49,304,092.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>553,624,110.92</u>	<u>-11,986,648.41</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>553,624,110.92</u>	<u>-11,986,648.41</u>

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>9,090,363,320.00</u>	<u>11,462,268,636.59</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	311,810,961.00	287,211,537.59
120	Нийтлэг татварын бус орлого	311,810,961.00	287,211,537.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	311,810,961.00	238,528,459.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	134,376,440.00	227,093,625.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	177,434,521.00	11,434,834.00
120009	Бусад орлого	0.0	48,683,078.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,778,552,359.00	11,175,057,099.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,769,293,000.00	9,887,685,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,769,293,000.00	9,887,685,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	1,287,371,799.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	1,204,497,995.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	82,873,804.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,259,359.00	0.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,259,359.00	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>8,995,845,320.00</u>	<u>11,394,795,632.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,995,845,320.00	11,394,795,632.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,865,526,895.83	11,284,939,624.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,331,055,942.00	1,349,932,500.30
210101	Үндсэн цалин	459,705,659.00	464,198,352.00
210102	Нэмэгдэл	7,495,900.00	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,455,700.00	0.0
210104	Урамшуулал	0.0	60,915,948.30
210105	Гэрээт ажлын хөлс	861,398,683.00	824,818,200.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	0.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,068,129.06	161,899,269.10
210201	Тэтгэврийн даатгал	143,068,129.06	161,899,269.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,292,582.79	185,788,615.49
210301	Гэрэл, цахилгаан	74,653,427.00	84,140,810.00
210302	Түлш, халаалт	75,970,694.00	78,608,300.00
210303	Цэвэр, бохир ус	22,668,461.79	23,039,505.49
2104	Хангамж, бараа материалын зардал	344,319,285.00	31,535,040.37
210401	Бичиг хэрэг	4,954,870.00	3,617,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,998,330.00	2,004,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,826,385.00	4,417,141.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,960,000.00	3,960,000.00

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	328,579,700.00	17,536,679.00
2105	Нормативт зардал	0.0	50,503,999.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	50,503,999.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	383,117,641.20	177,571,981.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	342,279,653.20	125,885,319.00
210604	Урсгал засвар	40,837,988.00	51,686,662.00
2107	Томилолт, зочны зардал	1,119,400.00	902,950.00
210702	Дотоод албан томилолт	1,119,400.00	902,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,044,778,737.78	8,270,826,055.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,037,952,525.78	8,140,521,227.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,573,800.00	4,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	870,900.00	840,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,200.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,200.00	0.0
210807	Газрын төлбөр	926,112.00	926,112.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	0.0	124,268,616.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	444,775,178.00	1,055,979,214.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	443,130,078.00	1,031,562,015.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,645,100.00	24,417,199.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,318,424.17	109,856,008.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	40,988,910.00	38,298,508.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	40,988,910.00	38,298,508.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,436,300.00	19,968,208.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,500,000.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,636,300.00	18,968,208.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,300,000.00	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,893,214.17	51,589,292.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,893,214.17	51,589,292.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>94,518,000.00</u>	<u>67,473,004.10</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	97,518,000.00	66,472,675.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,518,000.00	66,472,675.00
2200	Дотоод эх үүсвэрээр	97,518,000.00	66,472,675.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,518,000.00	66,472,675.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-97,518,000.00</u>	<u>-66,472,675.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,000,000.00	1,000,329.10
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,000,000.00	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,000,329.10

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	944,046,039.52	1,050,033,744.74	-82,611,083.46	1,911,468,700.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	944,046,039.52	1,050,033,744.74	-82,611,083.46	1,911,468,700.80
C07	Тайлант үеийн үр дүн			553,624,110.92	553,624,110.92
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	944,046,039.52	1,050,033,744.74	471,013,027.46	2,465,092,811.72
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	944,046,039.52	1,050,033,744.74	471,013,027.46	2,465,092,811.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	944,046,039.52	1,050,033,744.74	471,013,027.46	2,465,092,811.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		523,976,389.83		523,976,389.83
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	340,767,120			340,767,120
D08	Тайлант үеийн үр дүн			-11,986,648.41	-11,986,648.41
D09	2018 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл	1,284,813,159.52	1,574,010,134.57	459,026,379.05	3,317,849,673.14

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,977,685,300.00	9,953,619,008.47	24,066,291.53	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,977,685,300.00	9,953,619,008.47	24,066,291.53	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,913,297,500.00	9,896,352,292.47	16,945,207.53	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,318,995,900.00	1,318,995,900.00	-	100.0
210101	Үндсэн цалин	312,670,300.00	464,198,352.00	151,528,052.00	148
210102	Нэмэгдэл	75,149,000.00		75,149,000.00	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,785,000.00		15,785,000.00	0
210104	Урамшуулал	915,391,600.00	29,979,348.00	885,412,252.00	3
210105	Гэрээт ажлын хөлс		824,818,200.00	824,818,200.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,279,600.00	158,186,877.00	92,723.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	105,519,800.00	158,186,877.00	52,667,077.00	150
210202	Тэтгэмжийн даатгал	13,189,900.00		13,189,900.00	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,552,000.00		10,552,000.00	0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,638,000.00		2,638,000.00	0
210205	Эрүүл мэндийн даатгал	26,379,900.00		26,379,900.00	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,896,800.00	185,788,615.49	108,184.51	99.9
210301	Гэрэл, цахилгаан	94,266,600.00	84,140,810.00	10,125,790.00	89
210302	Түлш, халаалт	67,177,200.00	78,608,300.00	11,431,100.00	117
210303	Цэвэр, бохир ус	24,453,000.00	23,039,505.49	1,413,494.51	94

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	30,992,000.00	30,198,111.37	793,888.63	97.4
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,617,100.00	617,100.00	121
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,004,120.00	995,880.00	67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,880,000.00	4,417,141.37	1,462,858.63	75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,720,000.00	3,960,000.00	5,760,000.00	41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,392,000.00	16,199,750.00	6,807,750.00	172
2105	Нормативт зардал	50,635,000.00	50,503,999.00	131,001.00	99.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,635,000.00	50,503,999.00	131,001.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,775,400.00	201,571,971.00	203,429.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,000,000.00	149,885,309.00	114,691.00	100
210604	Урсгал засвар	51,775,400.00	51,686,662.00	88,738.00	100
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	902,950.00	1,097,050.00	45.1
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	902,950.00	1,097,050.00	45
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,394,272,800.00	7,401,098,275.51	6,825,475.51	100.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,386,858,800.00	7,395,062,063.51	8,203,263.51	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	4,200,000.00	800,000.00	84
210803	Даатгалын үйлчилгээ	840,000.00	840,000.00	-	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	539,000.00	70,100.00	468,900.00	13
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	105,000.00		105,000.00	0
210807	Газрын төлбөр	930,000.00	926,112.00	3,888.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	570,450,000.00	549,105,593.10	21,344,406.90	96.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	560,450,000.00	539,111,893.10	21,338,106.90	96

Биеийн тамир, спортын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	9,993,700.00	6,300.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,387,800.00	57,266,716.00	7,121,084.00	88.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	40,000,000.00	38,298,508.00	1,701,492.00	95.7
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	40,000,000.00	38,298,508.00	1,701,492.00	96
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,387,800.00	18,968,208.00	5,419,592.00	77.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,387,800.00	18,968,208.00	5,419,592.00	78
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,977,685,300.00	9,954,619,008.47	23,066,291.53	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,887,685,300.00	9,837,573,965.47	50,111,334.53	99.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,887,685,300.00	9,837,573,965.47	50,111,334.53	99.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,000,000.00	117,045,043.00	27,045,043.00	130.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000,000.00	103,325,009.00	13,325,009.00	114.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,720,034.00	13,720,034.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000,000.00	1,000,000.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	-	100.0

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2018.12.31

Аудитын
нэр:

Биеийн тамир, спортын газрын 2018 оны
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/84/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Биеийн тамир, спортын газар

мянган төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Худалдан авах ажиллагаа	1	Худалдан авах ажиллагаанд хийсэн сорилын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын "Спорт ба хөгжил" улсын зөвлөлгөөны лого, шторк хийх видео танилцуулга, баннер, олимпын тэмдэгт зоосны загварыг хийлгэх гэрээний хүлээлгэн өгөх эцсийн хугацаа 2018.10.18-нд байсан боловч хэрэгжилт хангагдаагүй	7,905.00	Албан шаардлага өгсөн			БТСГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Ш.Шаравцамж А.Уранбилэг
2	Цалин хөлс, нэмэгдэл	1	Төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, эрхэлсэн ажилдаа гаргасан амжилтыг үл харгалзан сар бүр бүх хүнд ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгосон		Зөвлөмж өгсөн			БТСГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Ш.Шаравцамж А.Уранбилэг
3	Авлага	1	2018 оны санхүүгийн тайланд 41 байгууллагын 687,677.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ба өмнөх оноос 218,690.9 мянган төгрөгөөр өссөн байна.	68,756.00	Зөвлөмж өгсөн			БТСГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Ш.Шаравцамж А.Уранбилэг